



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

**Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис,
эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг тогтоох тухай**

Монгол Улсын Хүнсний тухай хуулийн 5-р зүйлийн 5.1 дэх заалтыг үндэслэн
ТУШААХ нь :

1. Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг тогтоох журмыг хавсралтаар баталсугай.
2. Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг таваас арван жил тутамд хянаж, зохистой хэмжээг шинэчилж байхыг байхыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлалын хэлтэс/Ж.Батжаргал/-д үүрэг болгосугай.
3. Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэсийн зөвлөмж хэмжээг тогтоох журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс /С.Эвлэгсүрэн/-д, хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс, эслэгийн хэрэгцээг 5-10 жил тутамд хянан шинэчлэх, шинээр тогтооход шаардагдах зардлыг улсын төсөвт тусган шийдвэрлэж байхыг Санхүү, эдийн засгийн хэлтэс/Д.Дамдиндорж/-т тус тус даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ

001696

176
179
Эрүүл мэндийн сайдын
2013 оны 04 дугаар сарын 04
ний өдрийн 10.8 тоот тушаалын
хавсралт

**Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс,
аминдэмийн зохистой хэмжээг тогтоох журам**

Энэхүү журмын зорилго нь хүн амын хоногт хэрэглэвэл зохих хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг таваас арван жил тутамд хянан үзэж, шинэчлэн тогтоох ажлыг гүйцэтгэхэд баримтлах зарчим, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Нэг. Нийтлэг үндэслэл

ДЭМБ, Нэгдсэн Үндэстний Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага нь хүн амын хоногт хоол хүнсээр авах шаардлагатай үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс болон усны хэрэгцээг хүний нас, хүйс, биеийн жин, бодисын солилцооны онцлог, амьдралын хэв маяг зэрэгт тохируулан нарийвчлан тогтоодог. "Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээ" нь тусгайлан нэг хүнд бус нийгэм, эдийн засгийн ердийн нөхцөлд амьдарч буй харьцангуй эрүүл хүн амын нийтлэг бүлэгт зориулагддаг.

Улс орнууд хүн амынхаа "Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээ"-г янз бүрийн хугацааны давтамжтайгаар тогтоож ирсэн бөгөөд АНУ 1943 онд анх удаа тогтоосноос хойш 5-10 жилийн давтамжтайгаар шинэчлэн сайжруулсаар 2010 онд 11 дэх удаагаа шинэчлэн тогтоосон байдаг. Энэхүү зөвлөмж хэмжээ нь ДЭМБ болон дэлхийн ихэнх улс орны хүн амын хоногт хэрэглэвэл зохих хоол тэжээлийн бодисын зөвлөмж хэмжээний үндсэн лавлагаа болдог.

Манай Улсад "Монгол улсын хүн амын хоол тэжээлийн физиологийн норм" -ыг анх 1981 онд Анагаах ухааны хүрээлэн эрхлэн боловсруулсан бөгөөд үүнээс 15 жилийн дараа буюу 1997 онд ЭМНХЯ -ны харьяа Хоол Судлалын Төв нь "Хүн амын хоол тэжээлийн физиологийн нормыг нарийвчлан боловсруулсан. Энэ ажлын хүрээнд хоногт хоол хүнсээр авбал зохих үндсэн шимт бодисууд (уураг, өөх тос, нүүрс ус), илчлэг, аминдэм (А,С, В₁, В₂, В₆, РР), эрдэс бодисуудын (кальци, фосфор, төмөр) зөвлөмж хэмжээг 4-17 насны хүүхэд, насанд хүрэгсэд, тусгай зориулалтын хүнс хэрэглэх хүн амын бүлгүүдэд тус тус тогтоосон.

2006-2009 онд "Монгол хүний хоногийн хоол тэжээлийн физиологийн норм"-ын хүрээнд хоногт хоол хүнсээр авах илчлэгийн хэрэгцээг хүн амын насны бүлэг, хүйсээр ангилан тогтоож, үүнтэй уялдуулан В₁, В₂, В₆, РР аминдэмүүдийн зөвлөмж хэмжээ болон уураг, өөх тос, нүүрс усны хэрэгцээний аюулгүйн хэмжээг тус тус тогтоосон байна. Түүнчлэн ДЭМБ, ХХААБ-ын мэргэжлийн шинжээчдийн зөвлөмжийг үндэслэн 9 аминдэм, 12 эрдэс бодисын зөвлөмж хэмжээ болон өргөн хэрэглээний зарим хүнсний бүтээгдэхүүний хоногт хэрэглэвэл зохих хэмжээг өвөл, зуны улирлаар ангилан тогтоож, "Хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ"-ний агуулга, хэлбэр, зарим нэр томъёог олон улсын жишигт ойртуулан, шинэчилсэн.

177
180

Хоёр. Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг тогтоох судалгааны байгууллага

2.1 Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг 10 жил тутамд, шаардлагатай тохиолдолд 5 жил тутамд хянаж, шинэчлэх болон шинээр тогтоох саналыг эрүүл мэндийн салбарын хоол, шим судлалын эрдэмтэн, судлаачдын баг дэвшүүлж, ЭМЯ-ны захиалгаар Шинжлэх ухаан технологийн төсөлт ажил болон сэдэвт ажлын хүрээнд гүйцэтгэнэ.

2.2 Хоол тэжээлийн бодисууд, хүнсний бүтээгдэхүүний хоногт хэрэглэвэл зохих хэмжээг шинэчлэх болон шинээр тогтоох ажлыг эмнэл зүйн туршилт болоод хүн амын хоол тэжээлийн иж бүрэн судалгааны хүрээнд онол, арга зүйн өндөр түвшинд гүйцэтгэнэ.

2.3 Энэхүү ажил нь хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг тогтоох асуудлаар шинэ мэдлэг, мэдээллийг бий болгож, монгол хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт, хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг тодорхойлж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр баталгаажуулна.

Гурав. Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг тогтоох байгууллагад тавигдах шаардлага

3.1 Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг тогтоох ажлыг ЭМЯ-ны харьяа хоол судлалын мэргэжлийн байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

3.1 Хоол, шим судлалын эрдэм шинжилгээний салбарт 10-с доошгүй жил ажилласан, хүний их эмч, хоол зүйч мэргэжилтэй, эрдэм шинжилгээний тэргүүлэх зэрэгтэй, судалгааны ажлын дадлага туршлагатай эрдэмтэн судалгааг удирдан гүйцэтгэнэ.

3.2 Судлаачдын баг нь хүний их эмч, эрүүл ахуйч, хоол зүйч, технологичоос бүрдэнэ.

3.3 Судлаачдын багт цус, шээс, бусад биологийн дээж болон хүнсэнд лабораторын шинжилгээ хийх мэргэжилтэнүүд оролцоно.

3.4 Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг шинэчлэх болон нэмэлтээр тогтоох судалгааны ажлыг гүйцэтгэх судлаачдын багийг чадавхижуулах, өндөр хөгжилтэй орнуудад туршлага судлуулах, сургалтад хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

3.5 Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг шинэчлэн тогтоох эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагыг мэдээлэл боловсруулах орчин үеийн программ хангамжаар хангаж, мэргэжилтнийг сургаж, мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэнэ.

3.6 Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг шинэчлэх болон нэмэлтээр тогтоох судалгааны ажлын аргачлал боловсруулах болон мэдээлэл боловсруулах үе шатуудад олон улсын зөвлөх мэргэжилтэн ажиллуулах боломж нөхцөлөөр хангана.

Дөрөв. Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг шинэчлэн тогтоох судалгаа хийх хугацаа

4.1 Улс орны нийгэм, эдийн засгийн таагүй нөхцөл байдлаас үүдэн хүн амын дунд ядуурал, ажилгүйдэл нэмэгдэж, хоол хүнстэй холбоотой өвчин эмгэгийн тархалт тогтвортой буурахгүй, эсвэл нэмэгдэх хандлагатай үед хоол тэжээлийн үндэсний судалгааг 5 жил тутам явуулж, хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг ДЭМБ-ын зөвлөмж хэмжээтэй харьцуулан хянах ба тухайн өвчин, эмгэгтэй холбогдох болон нэмэлтээр тогтоох шаардлагатай хоол тэжээлийн бодисууд, хүнсний бүтээгдэхүүний норм хэмжээг шинэчлэн тогтооно.

4.2 Нийгэм, эдийн засгийн таатай орчин бүрдэж, ядуурал, ажилгүйдэл багасч, хүн амын дунд хоол хүнстэй холбоотой өвчин эмгэгийн тархалт буурах үед хүн амын хоол тэжээлийн байдалд үнэлгээ өгөх судалгааг 10 жилийн давтамжтай явуулж, хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээ ДЭМБ-ын зөвлөмж хэмжээтэй харьцуулан хянах ба шинэчлэх эсвэл нэмэлтээр тогтоох шаардлагатай хоол тэжээлийн бодисууд, хүнсний бүтээгдэхүүний зөвлөмж хэмжээг дахин тодотгож, шинэчлэн тогтооно.

Зохистой хэмжээ нь ДЭМБ-ын зөвлөмж хэмжээтэй дүйж, тухайн бодисын илүүдэл ба дуталтай холбоотой өвчин эмгэгийн тархалт эрс буурсан тохиолдолд уг бодисуудын зохистой хэмжээг өмнөх жилүүдэд тогтоосон байдлаар нь үргэлжлүүлэн мөрдөнө.

Тав. Судалгаагаанд ашиглагдах лабораторийн багаж, тоног төхөөрөмж, оношлуурт тавигдах шаардлага

5.1 Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг шинэчлэх болон шинээр тогтоох судалгааны бэлтгэл ажлыг 2 жилийн өмнөөс хангана.

5.2 Үндсэн шимт бодис, аминдэм, эрдэсийг цус, шээс болон бусад биологийн сорьц, хүнсний бүтээгдэхүүнд тодорхойлох өндөр хүчин чадал бүхий лабораторын багаж, тоног төхөөрөмж, оношлуурын бэлэн байдлыг хангасан байна.

5.3 Цус, шээс, бусад биологийн дээж болон хүнсэнд лабораторын шинжилгээ хийх мэргэжилтэнүүдийг давтан сургаж дадлагажуулсан байна.

Зургаа. Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг шинэчлэн тогтоох ажлын санхүүжилт

Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг 5-10 жил тутамд хянан шинэчлэх, шинээр тогтоох ажлын санхүүжилтийг дараах эх үүсвэрүүдээс бүрдүүлнэ. Үүнд:

6.1 Улсын төсөв (ШУТИС, ҮХААЯ, ЭМЯ, ХЗЯ, БШУЯ)

6.2 ЭМЯ-ны Эрүүл мэндийг дэмжих сан

6.3 Олон улсын байгууллагын дэмжлэг

6.4 Төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн хандив, тусламж

Долоо. Хүн амын хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээг шинэчлэн тогтоосон ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх

Шинэчлэн буюу шинээр тогтоосон хоногийн хэрэгцээт хүнс, үндсэн шимт бодис, эрдэс, аминдэмийн зохистой хэмжээ нь хүн амын хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, хянах, тэдний эрүүл мэндийг сахин хамгаалахад орших бөгөөд төслөөс гарсан үр дүнг дараах салбарын яам, газрууд ашиглана. Үүнд:

7.1 Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам

7.2 Эрүүл мэндийн яам

7.3 Боловсрол, Шинжлэх Ухааны Яам (сургууль, цэцэрлэг)

7.4 Хүнсний үйлдвэр, нийтийн хоолны газрууд

7.6 Мэргэжлийн хяналтын байгууллагууд

7.7 Нийгмийн хамгааллын яам

7.8 Хууль зүйн яам(ял эдлэгсдийн хоногт хэрэглэвэл зохих хоол тэжээлийн бодисын зөвлөмж хэмжээ)

7.9 БХЯ (цэргийн албан хаагчдын хоногт хэрэглэвэл зохих хоол тэжээлийн бодисын зөвлөмж хэмжээ)